Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар
тушаалын 6 дугаар хавсралт

# ХӨДӨЛМӨРИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Т.ЭНХЖАРГАЛЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Эхэлсэн, дуусан хугацаа | Хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилт 1: НЭГ. “ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААР ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЯНАЛТ ТАВИХ, ТАЙЛАГНАХ ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1. | Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр гарсан хууль тогтоомж, бодлого, шийдвэр , үндэсний болон аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, тайлагнах. | Хөтөлбөр хэрэгжсэн байна | 5 хөтөлбөр | Шинээр гарсан шийдвэр, хөтөлбөрүүдийг бүртгэж авсан байна | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан хөтөлбөрүүдийн хүрээнд журмын дагуу шаардлага хангасан иргэдийн төсөл хөтөлбөрүүдийг хүлээн авч холбогдох баримт бичгийн хамт бүрдүүлэн амьжиргаа дэмжих зөвлөлийн шийдвэрийн хамт ХХҮГазарт хүргүүлэн, санхүүгийн дэмжлэгт шаардлага хангасан иргэдийн төслүүдийг хамруулсан. Энэ онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй 21 иргэн төсөл боловсруулж өгсөн ба шаардлага хангасан 8 иргэнийг сургалтанд хамруулан санхүүжилтийг нь олгуулсан. | 2025.01.02 -2025.12.31 | |
| 2. | Хариуцсан ажлын чиг | | | | Ажил мэргэжлийн чиг баримжаа | 2025.01.02- | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үүргийн хүрээнд Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх, тайлагнах. | Зөвлөн туслах үйлчилгээ | 120 иргэн | 150 иргэн | олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд 30 иргэнийг хамруулсан. ХЭДСангаас 3240000 төгрөг зарцуулав. Мөн төсөл хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй 21 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээнд, 67 иргэнийг бүлгийн сургалт болон танхимаар сургалтуудад хамруулсан байна. Хүнсний эрхийн үйлчилгээнд хамрагддаг хөдөлмөрийн насны иргэдийг ажиллах боломжоор хангах тэднийг хөдөлмөрт бэлтгэх сэтгэл зүйн зөвлөгөө өгөх сургалтыг 3 удаа зохион байгуулсан нийт давхардсан тоогоор 37 иргэн хамрагдсан байна. | 2025.12.31 | |
| 3. | Нийтийг хамарсан ажил хийх төсөл боловсруулан холбогдох байгууллагаас дэмжлэг авч, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх тус ажилд бүртгэлтэй ажилгүйчүүдийг хамруулж, түр ажлын байраар хангах, тайлагнах | Нийтийг хамарсан ажлын төслийг боловсруулан санхүүгийн дэмжлэг авах | 45 ажилгүй иргэн | 40 ажилгүй иргэн түр ажлын байраар хангах | Нийтийг хамарсан ажилд 2080000 төгрөг ХЭДСангаас зарцуулагдаж иргэдийн амьжиргаанд тус дэм болсон. Нийт 45 иргэн түр ажлын байраар хангагдсан байна. | 2025.01.02-2025.12.31 | |
| 4. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн дагуу бүртгэлтэй ажилгүй иргэнийг ажилд авч тогтвортой ажиллуулсан тохиолдолд тухайн байгууллагад хуулийн заалт хэрхэн хэрэгжиж | 1 аж ахуй нэгж | 1 аж ахуй нэгж | 12 сард 1 аж ахуй нэгж | Аж ахуйн нэгжүүдэд ажлын байрны урамшууллалын тухай журмыг сурталчилан гарын авлагааар хангаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг болох зорилгоор аж ахуй нэгжүүдэд сургалтыг 1 удаа зохион байгуулсан байна. ХБИргэнийг ажлын байраар хангасан Жем- | 2025.01.02-2025.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгаад хяналт тавих. | | | | Хужирт ХХК урамшуулалд хамрагдахаар холбогдох баримт бүрдүүлэн дараагийн шатны байгууллагад шилжүүлсэн. | | |
| 5 | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаарх хууль тогтоомж стандартыг аж ахуй нэгж, байгууллага, ажлын байранд мөрдүүлж хэвшүүлэх | Хяналт тавьж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн аж ахуй нэгжийн тоогоор | 3 аж ахуй нэгж | 4 аж ахуй нэгж | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг сурталчлан таниулах зорилгоор жил бүр 4 сарыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах сар болгон зарласантай холбоотойгоор энэ жил хууль тогтоомжийг сурталчлах төлөвлөгөөний дагуу 5 ажлыг зохион байгуулан тайлан мэдээг холбогдох газар нь хүргүүлэн ажилласан. Энэ жил ажлын байран дээр интернэт орчинд зөв ажиллах, мөн соронзон долгионоос хэрхэн сэргийлэх талаар ажлын байрандаа ажиллах жил болгон зарласан бөгөөд 16 аж ахуйн нэгжид мэдээллийг хүргэж ажилласан ба үйл ажиллагаанд нь дэмжлэг болох зорилгоор 9 аж ахуйн нэгжд сургалтыг 1 удаа танхимаар зохион байгуулсан. Энэ сургалтанд улсын чанартай үйл ажиллагаа явуулдаг 6 рашаан сувилал, мөн Жем- Хужирт усны үйлдвэр, Баян булаг ХХК , Хужирт-илч ХХК хамрагдсан. Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газрын зөвлөн туслах баг Ананд , Элма-Хужирт, Сэмжид , Хужирт рашаан сувилалуудад аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хөдөлмөрийн тухай хууль, тогтоомжийн мэдлэг ойлголтыг | 2025.01.02-2025.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нэмэгдүүлэх зорилгоор зөвлөн туслах үйлчилгээ 8 сард тус бүр нэг удаа үзүүлэн ажилсан байна. | | |
| Зорилт 2: “ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙГ САЙЖРУУЛЖ , ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1. | Ажилгүй иргэдийн судалгааг гарган, бүртгүүлсэн хүн бүрт карт хөтөлж, мэдээллийн сангийн баяжилтыг тогтмол хийж хэвших. | Профайленгийн үйлчилгээг үзүүлсэн байна. | 30 иргэнд | 30 иргэн | Оны эхнээс нийт 30 иргэнд профайленгийн үйлчилгээ үзүүлсэн. Энэ нь ажилгүй, ажил олгоход хүндрэлтэй иргэний сэтгэл зүйн шинжилгээ хийх арга хэмжээ юм. Мөн ажилгүй зорилтод бүлгийн 30 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, бэлтгэх сургалтыг хийсэн. | 2025.01.02-2025.12.31 | |
| 2. | Ажилгүй иргэдийн сургалтын хэрэгцээг тодорхойлж тэдэнд чиглэсэн арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах, мэргэжлийн сургалтад хамруулах мэргэжилтэй болох. | Жилдээ 10-оос доошгүй иргэнийг мэргэжилтэй болгосон байна. | 10 иргэн | 10 иргэн | Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд 30 иргэнийг хамруулсан. ХЭДСангаас 3240000 төгрөг зарцуулав. Мөн төсөл хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй 21 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээнд, 67 иргэнийг бүлгийн сургалт болон танхимаар сургалтуудад хамруулсан. Хүнсний эрхийн үйлчилгээнд хамрагддаг хөдөлмөрийн насны иргэдийг ажиллах боломжоор хангах тэднийг хөдөлмөрт бэлтгэх сэтгэл зүйн зөвлөгөө өгөх сургалтыг 3 удаа зохион байгуулсан нийт давхардсан тоогоор 37 иргэн хамрагдсан байна. | 2025.01.02-2025.12.31 | |
| Зорилт 3: “ШИНЭЭР АЖЛЫН БАЙР БИЙ БОЛГОХОД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ” | | | | | | | |
| 1. | ХЭДСанийн дэмжлэгээр бий болсон ажлын байрыг тогтвортой | Ажилтай болсон иргэдийн | 10 иргэн | 10 иргэн | ХЭДсанийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн ажлын байрны дэлгэрэнгүй судалгааг гаргаж | 2025.01.02-2025.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хадгалах | тоогоор | | | ХЭСДсангийн санхүүжилтээр нийт 9 шинэ ажлын байр, түр 12 ажлын байр бий болсон байна. ХЭДСангийн дэмжлэгээр өрхийн үйлдвэрлэл эрхлэж байгаа иргэдээ чадвахжуулах тал дээр анхаарч ажиллаж байна. 2024 онд малжуулах хөтөлбөрт хамрагдсан 3-р багийн нэг малчин залууг ХЭДСангийн зардлаар Өвөрмонголын шилийн гол аймагт нэг удаа сургалтанд хамруулав. | | |
| 2. | Шинээр бий болсон ажлын байрны болон бусад мэдээллийг аж ахуй нэгж байгууллагаас цуглуулах, ажлын байрны захиалга авах зуучлах. | Бий болсон ажлын байрны тоогоор | 170 иргэн ажлын байртай болох<br>Зуучлалаар 80 | 10 иргэн | Орон нутагт хэрэгжүүлж байгаа томоохон бүтээн байгуулалт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрийн үр дүнд 141 ажлын байр бий болсон. Улирлын чанартай худалдаа үйлчилгээ болон амралт сувилалын газар бий болдог ажлын байранд 51 иргэн улирлын ажлын байраар, мөн төсөвт болон ААНэгжид 53 иргэн байнгын ажлын байртай болсон байна. 37 иргэн зуучлалаар түр ажлын байраар хангандсан байна. Үүнээс гадна Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр 1 малчин малжуулах хөтөлбөрт хамрагдаж 8 сая төгрөгийн мал, Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2 иргэн 12 сая, Ахмадын хөтөлбөрт 2 иргэн 10 сая, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөтөлбөрт 1 иргэн хамрагдаж 6 сая төгрөгийн санхүүжилт авсан. Ахмадын зөвлөн туслах үйлчилгээнд 2 ахмад настан | 2025.01.02-2025.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамрагдаж тус бүр 1080000 төгрөг авлаа. | | |
| Зорилт 4: “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1 | Төрийн албаны тухай хууль төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, журмыг чанд мөрдөн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжүүлэх, удирдлагыг мэдээллээр хангах | Ёс зүйн зөрчил дутагдалгүй ажилласан байна. | Томилогдсон ажлын хэсэг, авсан үүрэг даалгаврыг биелүүлэх | Томилогдсон ажлын хэсэг бүрт | Төрийн албаны хууль болон төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдөн ажиллаж ёс зүйн зөрчил гаргаагүй. Ёс зүйн сургалтанд танхимаар 1 удаа хармагдсан. | 2025.01.02-2025.12.31 | |
| 2 | Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу баримтыг эмхлэн цэгцэлж, байгууллагын архивт хүлээлгэн өгөх | Стандартыг мөрдөж биелүүлсэн байна. | Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх | Байнга | 2024 оны бичиг баримтыг үдэн цэгцэлж архивт хүлээлгэн өгсөн. Албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж ажиллаж байна. Архив бичиг хэргийн шинэчлэгдсэн журмыг өдөр тутмын ажилдаа нэвтрүүлэн ажиллаж байна. | 2025.01.02-2025.12.31 | |

**ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Эхэлсэн, дууссан хугацаа | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Төрийн албаны зөвлөлийн сургалтууд болон цахим сургалтад хамрагдаж хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | Шинэ гарсан хууль тогтоомжийн биелэлтийг хангаж ажиллана | 2 сургалт | 2 сургалт | Өөрөө бие даан хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлж байна. ХХҮГазараас зохион байгуулсан төрийн албаны шинэчлэл хуулийн сургалтад танхимаар 3 удаа хамрагдсан. | 2025.01.02-2025.12.31 | |
| 2 | Мэдээллийн технологи болон бусад зайлшгүй шаардлагатай ур чадвараа дээшлүүлж өөрийн мэдлэг чавдараа тасралтгүй | Мэдээлэл технологи болон ур чадвараа | 1 | 3 удаа сургалтуудад хамрагдсан. | Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа боломжийг ашиглан орчин үеийн мэдээллийн технологийн аргад суралцаж, | 2025.01.02-2025.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөгжүүлж, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцах | ахиулсан байх | сургалт | | ажилдаа нэвтрүүлэн ажиллаж байна. Цахим орчны халдлагаас сэргийлэх сургалтад 1 удаа хамрагдсан. Мөн холбогдох сургалтуудад 4 удаа хамрагдав. | | |
| 3 | Ажил мэргэжилтэй холбоотой сургалт семинарт хамрагдан, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж, холбогдох хууль тогтоомжийг судалж, үйл ажиллагаандаа мөрдлөг болон ажиллах. | Сургалтанд хамрагдаж мэдлэгээ гүнзгийрүүлэх | 1 удаа сургалт | 1 сургалт | ХХҮГазрын албан хаагчидаа чадваxжуулах сургалтанд нэг удаа хамрагдаж холбогдох хуулийн шинэчлэлийн талаар мэдээлэл авсан. ХАБЭА-н сургалтад танхимаар 2 удаа сургалтанд хамрагдав. | 2025.01.02-2025.12.31 | |
| 4 | Үндэсний бичгийн чадвараа ахиулан өдөр тутмын албан хэрэг хөтлөхдөө ашиглах. | Сургалт, арга хэмжээнд тухай бүр хамрагдсан байна. | Унших бичих чадварт ай | Унших бичих чадвар ахисан. | “Хүмүүн бичиг” сонин захиалан уншиж, бичих чадвараа дээшлүүлж байна. Ахмад мэргэжилтний зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдаж буй багшийн 120 цагийн сургалтанд хамрагдав. | 2025.01.02-2025.12.31 | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХӨДӨЛМӨРИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ................................. Т. ЭНХЖАРГАЛ ......... ......... .........

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*